

-Цагдаагийн ерөнхий газрын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны дэргэд тусгайлсан эдийн засгийн мэдлэгтэй алба хаагчдаар бүрдсэн тусгай хэлтсийг байгуулан ажиллуулах,

-Мөнгө хүүлэгчдийн татвар төлхөөс зайлс хийж байгаа үйлдлийг илрүүлэх ажлыг эричмжүүлэх саналыг дэвшүүлж байна.

Л.Ганшагай -Хууль сахиулахын их сургууль, Хууль сахиулах удирдлагын академийн 8032 дугаар дамжааны суралцагч.цагдаагийн дэд хурандаа
Д.Энхбаяр -ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА МӨНГӨ УГААХ ГЭМТХЭРГИЙН ШАЛТГААНТ ХОЛБОО, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Товч агуулга: Монгол Улсад ломбард буюу барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа бусад оронд хэрхэн яаж явагддаг, хууль эрх зүйн ямар зохицуулалт байдаг, онол туршлагын талаар тоймлон авч үзэж мөнгө угаах гэмт хэрэг ЛОМБАРД-ны ард нуугдмал хэлбэрээр оршин байж болзошгүй зэргийг харуулан дүгнэж, тодорхой санал дэвшүүлсэн.

Түлхүүр үг: Ломбард буюу барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, мөнгө угаах гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаант холбоо, урьдчилан сэргийлэх арга зам.

ОРШИЛ

Барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбардны тоон мэдээлэл, нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл тэр тусмаа гэмт хэргийн нөхцөл байдалд хэрхэн яаж нөлөөлж байгаа талаар энэхүү илтгэлээр харуулахаар судлав. Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 28.7-34.5 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг эзэлдэг бөгөөд энэ үзүүлэлт жил бүр өсөн нэмэгдэж байна. Гэмт хэргийн улмаас олсон эд зүйлийг мэдсээр байж авсан үйлдэл нь мөнгө угаах гэмт хэргийн нуугдмал шинжийг агуулж Эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиар хариуцлага хүлээлгэж байна. Иймд дээрх хоёр үйлдлийн шалтгаант холбоог нарийвчлан судалан тогтоосны үндсэн дээр тулгуурлан урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулан хэрэгжүүлэх нь чухал бөгөөд өнөөгийн нийгэмд тулгарсан хүндрэл бэрхшээлтэй харилцааны

нэг салбар болсон байна. Энэ салбарт жилд 30 гаруй тэм бум төгрөг эргэлдэж байгаа албан бус тооцоо байдаг. Энэ их мөнгний цаана мөнгө угаах гэмт хэрэг давхар явж байгааг үгүйсгэх араггүй юм. Хууль бус үйлдэл хаана ямар орчин нөхцөлд явагддаг вэ? хууль эрх зүйн орчин бүрдээгүй, хуулийн цоорхой, хийдэлтэй газар, орчинд бий болдог. Монгол Улсын хувьд ломбардны нарийвчилсан тоон болон статистик мэдээлэл байдаггүй, ломбардны үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл үнэн зөв бус хомс, учир дутагдалтай, шаардлага хангахгүй зэрэг нөхцөл байдлууд нь мөнгө угаах төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг шинжлэн тогтооход сөргөөр нөлөөлж байна. Өөрийн цуглуулсан мэдээллийг боловсруулж Монголын барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа ба мөнгө угаах гэмт хэргийн шалтгаант холбоо, урьдчилан сэргийлэх арга замыг бий болгохыг зорьсон болно.

ҮНДСЭН ХЭСЭГ: -БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СУДАЛГАА

Монгол Улсад 2015 онд 460, 2016 онд 586, 2018 оны 10 сарын байдлаар 736 ломбард үйл ажиллагаа явуулж байгаа судалгаа байна. Ломбардуудыг эргэлдэж байгаа мөнгө нь 20 саяас 3 тэр бум төгрөгийн хооронд байна. Нийт 30 гаруй тэр бум төгрөг энэ салбарт эргэлдэж байна.

Монголын Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах холбооноос Монгол Улсын хүн амын бүсчлэл тэдгээрийн барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдээр үйлчүүлж буй иргэдийн судалгааг түүвэрлэн гаргав.

№	Чиглэлүүд	Хоо хэмжээ	Ломбардаар үйлчлүүлж буй иргэд	Барьцаалагдаж буй эд зүйл
	Монгол Улсын нийт хүн ам	3.250.000		
1	0-18 насны хүүхэд	1,200,000		
2	Тэтгэвэрийн насныхан	180.000	75.906	Алт мөнгөн эдлэл, гар утас Автомашин
3	Жирэмсэн эхчүүд болон 0-3 насны хүүхэдтэй эхчүүд	190.000	86.965	Алт мөнгөн эдлэл, гар утас Автомашин
4	Их дээд сургуулийн оюутан	250.000	157.893	Алт мөнгөн эдлэл, гар утас Автомашин
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	150.000	98.500	Алт мөнгөн эдлэл, гар утас Автомашин

6	Ажилгүй иргэд	300.000	205,865	Алт мөнгөн эдлэл, гар утас Автомашин
7	Хөдөлмөр эрхэлдэг	750.000	198,803	Алт мөнгөн эдлэл, гар утас Автомашин
8	Ажил олгогч иргэд	56.000	12,500	Автомашин
9	Малчид болон бусад	20.000		
10	Гадаадад амьдардаг иргэд	210.000		
11	Нийт		761.507	

Нийслэлийн хэмжээнд Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн судалааны дүн:

№	Ажилчдын ТОО	Ломбардны тоо	Дундаж ажилчдын тоо
1	30-40	3	105
2	20-30	11	385
3	10-20	44	660
5	5-10	170	1190
6	2-5	508	2032
7	нийт	736	4.372

Цагдаагийн байгууллагын гомдол мэдээлэл, гэмт хэргийн бүртгэлээс авч үзэхэд:

Улаанбаатар хотын хэмжээнд 2017 оны эхний 8 сарын байдлаар албан байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс 57.733 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 16.920 буюу 29,3 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гомдол, мэдээлэл.

2017 оны эхний 8 сард 12.807 гэмт хэрэг бүртгэгдсэний 4.602 буюу 35,9 хувийг нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг эзэлсэн байна. Урд оны мөн үеэс 193 хэргээр буюу 4,4 хувиар өссөн. Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 4.019 буюу 87,3 хувийг хувийн өмчийн хулгай, 407 буюу 8,8 хувийг халаасны хулгайн гэмт хэрэг, 63 буюу 1,4 хувийг мал хулгайлах, 87 буюу 1,9 хувийг авто тээврийн хэрэгслийг хулгайлах, галт зэвсэг алдагдсан 1 хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсад мөнгө санхүү, зээлийн үйл ажиллагаа явуулдаг гурван субъект байгаагаас арилжааны банкуудыг Монгол банк, банк бус санхүүгийн байгууллагыг Санхүүгийн зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгон үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилладаг.

Харин барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын /ломбард/ үйл ажиллагаанд хяналт тавих эрх зүйн тогтолцоо, субъект тодорхойгүй зөвхөн Монгол Улсын Иргэний хууль /286 дугаар зүйл/, Зөрчлийн тухай хууль, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 35 дугаар тогтоолоор батлан гаргасан "Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ. ерөнхий шаардлага MNS5274-2017 стандарт", Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1999 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний ажиллах журам" зэрэг хууль, журмын хүрээнд үйл ажиллагаа нь зохицуулагддаг.

Судалгаа дүн шинжилгээ:

2018 оны 03 дугаар сард Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газар, дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдтэй хамтран "Ломбард" нэгдсэн арга хэмжээ явуулсны дүнд 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 598 барьцаалан зээлдүүлэх газрууд бүртгэгджээ. Дээрх ломбардуудад зах зээлийн хамгийн доод ханшаар тооцон үзэхэд 32 тэрбум 43,8 сая төгрөгөөр үнэлэгдсэн телевизор, нөүтбүүк, мөнгөн аяга, алт мөнгөн эдлэл, гар утас барьцаанд тавигдсан байна. Нийслэлд 2016, 2017 2018 оны эхний 3 сард үйлдэгдсэн гэмт хэргийн замаар алдагдсан халдлагын зүйлийг зах зээлийн доод ханшаар тооцож үзэхэд 7 тэрбум 737 сая төгрөгийн эд зүйл алдагдсан байна. Нийслэлийн 6-н дүүргийн хэмжээнд нийт 598 барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбард бүртгэгдэж үүнд 161,235 иргэн үйлчлүүлсэнээс зурагт-2826 ширхэг, нөүтбүүк-2417 ширхэг, мөнгөн аяга-31456 ширхэг, алт, монет, мөнгөн эдлэл-68579 ширхэг, гар утас-54466, бусад эд зүйл-35735 ширхэг барьцаанд тавигдсан байна.¹

Нийслэлийн Татварын газраас судалгаанд хамрагдсан 598 ломбардын буюу Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага иргэн, аж ахуйн нэгжийн татвар төлдөг эсэх талаар лавлагаа авахад 307 Ломбард буюу 55 хувь нь татвар төлдөггүй гэсэн байна. Дээрх татвар төлөхгүй үйл ажиллагаа

¹ НЦГ-ын Мөрдөн шалгах газрын Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлсээс гаргасан хулгайн гэмт хэргийн судалгаа 2018 он

явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд нь Нийслэлийн татварт 1 ломбард жилд хэдэн төгрөгний татвар төлөхөөс зайлсхийж байгааг одоогоор тодорхойлох боломжгүй байгаа бөгөөд дунджаар бодож үзэхэд: Давхардсан тоогоор Нийслэлийн хэмжээнд татвар төлөхгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа 307 барьцаалан зээлдүүлэх буюу ломбардын үйл ажиллагаа эрхэлж 1 ломбардаас 1 жилд дунджаар 11.6 сая төгрөгний татвар хураамж авна гэж үзвэл 1 жилд 3 тэр бум 561,2 сая төгрөгний татвар хураамж төлөх боломжтой гэж үзэж болохоор байна. Нийслэлийн татварын газраас барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж татвар төлж байгаа аж ахуйн нэгжүүдээс 8 төрлөөр татварын хураамж авдаг байна.Үүнд:

- 1 .Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
- 2 .Дотоодын бараа үйлчилгээний татвар
- 3 .Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого
- 4 .Үл хөдлөх хөнгийн татвар
- 5 .Нийслэл хотын албан татвар
- 6 .Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар
- 7 .Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар
- 8 Хог хаягдлын хураамжийн татвар

Нийслэлийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт хамгийн олон буюу 130 ломбард үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2015 онд 475,5 сая төгрөг, 2016 онд 441,5 сая төгрөг буюу хамгийн өндөр татварыг нийслэлийн татварын газарт төлсөн байна.

Нэг жилд төлөгдсөн 475,5 сая төгрөгний татварыг Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа татвар төлсөн ломбарданд хувааж үзэхэд нэг ломбард дунджаар жилд 11,6 сая төгрөгний татварыг улсын төсөвт төлсөн байна.

ИЛТГЭЛИЙН ХАВСРАЛТ:

Нийслэл хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа барьцаалан зээлдүүлэх 598 ломбардыг бүртгэлжүүлэн тухайн ломбардаар 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд үйлчлүүлсэн 161,235 иргэдийн нэрс, үйлчлүүлсэн он, сар, өдөр, тавьсан эд зүйлсийн судалгааг нэгтгэн сан үүсгэн дүн шинжилгээг холбогдох аргаар гүйцэтгэн ажиллахад:

Дүүрэг дэх пагдалгийн хэлтэс	Ломбард	Үйлчлүүлэгч н иргэдийн тоо	Зурагт	Нөтбүүк	Мөнгөн аяга	Алт, монет, мөнгөн эдлэл	Гар утас	Бусад
БГДЦХ-1	53	13200	156	115	215	1480	8532	2
БГДЦХ-2	61	7215	25	113	288	1374	3669	1746
БЗДЦХ-1	40	19379	254	439	8826	8520	728	612
БЗДЦХ-2	72	11000	163	565	4358	2926	1365	1623
БЗДЦХ-3	19	5179	78	326	2988	533	557	697
СХДЦХ-1	35	41444	217	92	2667	4044	28114	6310
СХДЦХ-2	25	4216	958	66	544	835	1006	807
СХДЦХ-3	41	13269	256	172	559	1303	7429	3550
СБДЦХ-1	48	7991	24	113	86	5699	908	1161
СБДЦХ-2	37	13819	455	143	3063	4685	569	4904
ЧДЦХ-1	60	2886	6	30	102	1271	156	1321
ЧДЦХ-2	21	13991	52	21	100	8732	798	4288
ХУДЦХ-1	22	8237	15	86	98	6263	216	1559
ХУДЦХ-2	13	20240	45	119	4793	15076	131	76
БНДЦХ	13	4065	13	1	2152	347	130	1422
НДЦХ	13	9400	161	16	617	5491	158	2957
НИЙТ	598	161235	2826	2417	31456	68579	54466	35735

Нийслэлийн 6-н дүүргийн хэмжээнд нийт 598 барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбард бүртгэгдэж үүнд 161,235 иргэн үйлчлүүлсэнээс зурагт-2826 ширхэг, нөүтбүүк-2417 ширхэг, мөнгөн аяга-31456 ширхэг, алт, монет, мөнгөн эдлэл-68579 ширхэг, гар утас-54466, бусад эд зүйл-35735 ширхэг барьцаанд тавигдсан байна. Нийслэлийн утаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 598 Барьцаалан зээлдүүлэх газруудад 2016 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 15-ны хооронд барьцаанд тавигдсан зарим эд зүйлсийг зах зээлийн доод үнэ ханшаар бодож үзэхэд:

Зурагт тоо ширхэг	Зах зээлийн доод үнэ	Нөтбүүк тоо ширхэг	Зах зээлийн доод үнэ	Мөнгөн аяга тоо ширхэг	Зах зээлийн доод үнэ	Алт, монет, мөнгөн эдлэл тоо ширхэг	Зах зээлийн доод үнэ	Гар утас тоо ширхэг	Зах зээлийн доод үнэ
2826	450,000 төг	2417	500,000 төг	31456	180,000 төг	68579	150,000 төг	54466	250,000 Төг
	1,271,0 төг		1,208,5 төг		5,662,0 төг		10,286,8 төг		13,616,5 Төг
НИЙТ	32,043,8 САЯ ТӨГРӨГ								

Зурагт 2826 ширхэг буюу 1,271,0 сая төгрөг, компьютер нөүтбүүк 2417 ширхэг буюу 1,208,5 сая төгрөг, мөнгөн аяга 31456 буюу 5,662,0 төгрөг, алт мөнгө монетон эдлэл 68579 буюу 10,286,8 сая төгрөг, гар утас 54466 ширхэг буюу 13,616,5 сая төгрөг нийт 32,043,8 сая төгрөгний эд зүйл барьцаалан зээлдүүлэх газруудад барьцаанд тавигдсан байгаа ба эдгээрээс татвар төлсөн талаар мэдээлэл байхгүй байна.

Манай улсад үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн 31.9 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Барьцаалан зээлдүүлэх газрууд нь хуулийн ямар ч зохицуулалтгүй байгааг ашиглан мөнгө хүүлэх, хулгайн гэмт хэргийн замаар олсон эд зүйлийг мэдсэн ч мэдээгүй мэтээр хүлээн авч цааш дамлан худалдаж их хэмжээний ашиг олохоос гадна Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар зүйл. /Татвар төлөхөөс зайлс хийх/, 18.6 дугаар зүйл. /Мөнгө угаах/ гэмт хэргүүд үйлдэгдэж байж болзошгүй байна. Нийслэл хотод үйлдэгдсэн бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн улмаас түгээмэл алдагдаж буй эд зүйлсийг түүвэрлэж гаргахад:

л/д	Алдагдаж буй эд зүйлсийн төрөл	Алдагдаж буй эд зүйлс	2015 онд	2016 онд	2017 оны 1-р улирал
1	Авто машины эд анги	Авто машин	140	197	34
2		Толъ	910	756	154
3		Дугуй	618	240	48
4		Гэрэл, дохио	174	182	51
5		Гупер	25	31	7
6		Аккумулятор	174	221	78
7		Копут	7	6	1
8		Хучлага	177	104	44
9		Төгрөг	817.581.550	798.566.998	135.647.080
10	Мөнгө, валют	Ам.доллар	95301	68542	61612
11		Юань	66470	58440	5720
12		Евро	730	1200	60
13		Вон	2.590.000	32102	2.350.000
14	Гар утас	Гар утас	1623	3215	305
15	Компьютер	Компьютер	737	757	165
16		Ээмэг	508	685	212
17		Бөгж	598	991	145
18	Алт, мөнгө, монетон эдлэл	Кулон	42	178	41
19		Гинж	295	252	66
20		Бусад	296	315	128
21	Алт, мөнгөн аяга	Мөнгөн аяга	1382	1583	376
22	Хөөрөг	Хөөрөг	291	325	76
23	Зурагт	Зурагт	1238	1997	424

Нийслэлийн цагдаагийн газрын хоногийн мэдээнээс харахад өдөрт дунджаар зурагт 4 ширхэг, компьютер 2 ширхэг, гар утас 3 ширхэг, алт, мөнгөн аяга 4 ширхэг, алт, мөнгө, монетон эдлэл 6 ширхэг, хөөрөг 1 ширхэг, авто

машины эд анги 6 ширхэг. 3 хоног тутамд 1 тээврийн хэрэгсэл тус тус хулгайд алдагдаж байна. Дээрх хулгайн гэмт хэргийн улмаас алдагдаж байгаа эд зүйлсийн заримыг нь зах зээлийн доод үнэ ханшаар бодож үзэхэд:

д/д	Эд зүйлийн нэр	Алдагдсан он	Тоо ширхэг	Зах зээлийн дундаж үнэ	2015 он	2016 он	2017 он	Нийт үнэ
1	зурагт	2015 он	1238	450,000 төг	557,1 сая			557,1 сая
		2016 он	1997	450,000 төг		898,6 сая		898,6 сая
		2017 оны 1 дүгээр улирал	424	450,000 төг			190,8 сая	190,8 сая
2	Компьютер, нөөтбүүк	2015 он	737	500,000 төг	368,5 сая			368,5 сая
		2016 он	757	500,000 төг		378,5 сая		378,5 сая
		2017 оны 1 дүгээр улирал	165	500,000 төг			82,5 сая	82,5 сая
3	Мөнгөн аяга	2015 он	1382	180,000 төг	248,7 сая			248,7 сая
		2016 он	1583	180,000 төг		284,9 сая		284,9 сая
		2017 оны 1 дүгээр улирал	376	180,000 төг			67,6 сая	67,6 сая
4	Алт монет мөнгөн эдлэл	2015 он	1739	150,000 төг	151,7 сая			151,7 сая
		2016 он	2421	150,000 төг		363,1 сая		363,1 сая

		2017 оны I дүгээр улирал	592	150,000 төг			88,8 сая	88,8 сая
--	--	--------------------------	-----	-------------	--	--	----------	----------

		2015 он	1623	250,000 төг	405,7 сая			405,7 сая
--	--	---------	------	-------------	-----------	--	--	-----------

5	Гар утас	2016 он	3215	250,000 төг		803,7 сая		803,7 сая
		2017 оны I дүгээр улирал	305	250,000 төг			76,2 сая	76,2 сая

6	Хөөрөг	2015 он	291	800,000 төг	232,8 сая			232,8 сая
		2016 он	325	800,000 төг		260,0 сая		260,0 сая
		2017 оны I дүгээр улирал	76	800,000 төг			60,8 сая	60,8 сая

7	Авто машины толь	2015 он	910	200,000 төг	182,0 сая			182,0 сая
		2016 он	756	200,000 төг		151,2 сая		151,2 сая
		2017 оны I дүгээр улирал	154	200,000 төг			30,8 сая	30,8 сая

8	Авто машины гэрэл дохио	2016 он	182	250,000 төг		45,5 сая		45,5 сая
		2017 оны I дүгээр улирал	51	250,000 төг			12,7 сая	12,7 сая

9	Монгол төгрөг	2015 он	817,581,550	817,581,550	817,5 сая			817,5 сая
		2016 он	798,566,998	798,566,998		798,5 сая		798,5 сая
		2017 оны I дүгээр улирал	135,647,080	135,647,080			135,6 сая	135,6 сая

10	Авто машин	2015 он	140					
		2016 он	197					

/Хулгайн гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлсээс гадаад валют, болон авто машины эд анги, алт, мөнгө, монетон эдлэлийг тус бүрээр нь гаргаж тооцоогүй дундажлан тооцсон болно./¹

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ

Олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан шилжүүлсэн үйлдэл нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томьёоллыг ашигладаг. Мөнгө угаахтай тэмцэхийн гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд нь давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршино. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой юм.

1. Олон улсын стандарт буюу НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенцид мөнгө угаах үйлдлийг дараах байдлаар тодорхойлжээ:

-Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;

- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;

-Тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;

-Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөх гэж тодорхойлсон байдаг.

¹ НЦГ-ын Мөрдөн шалгах газрын Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлсээс гаргасан хулгайн гэмт хэргийн судалдгаа 2018 он

2. Мөнгө угаах үе шат

Мөнгө угаах нь гэмт хэрэгтнүүдийн хувьд хууль бус орлогын эх үүсвэрээ аливаа эрсдэлд оруулалгүйгээр түүнээс олсон ашиг, орлогоо тааваараа ашиглахад туслах, санхүүгийн аюулгүй байдлаа хамгаалахад чиглэгдсэн маш чухал үйл явц юм. Мөнгө угаах гэмт хэрэг нь байршуулах, тараах буюу гүйлгээнд оруулах, буцааж төвлөрүүлэх гэсэн 3 үе шаттайгаар хийгддэг.¹

Эхний үе шат буюу байршуулах үе шатанд хууль бусаар олсон мөнгөө хаа нэгтээ байршуулах шаардлагатай байдаг. Тухайлбал, гэмт этгээд өөр хүний нэр дээр банкинд нээлгэсэн дансанд хууль бусаар олсон мөнгөө анхаарал татахааргүй хэмжээтэйгээр таслан хийх, үнэт цаас, чек, хувьцаа худалдан авах, эсхүл байр, байшин ч худалдан авах замаар байршуулж болно.

Хоёр дахь үе шатанд гарал үүслийг нь нуун далдлах, хууль ёсны орлого мэт харагдуулах зорилготойгоор нэгэнт байршуулсан мөнгөө эргэлтэнд оруулдаг. Жишээлбэл, худалдан авсан үнэт цаас, аяллын чекээ эргүүлэн зарах эсвэл гадаад худалдаа эрхэлж буй мэт харагдуулах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх хяналтын механизм бүрдүүлээгүй орнууд руу шилжүүлэх гэх

Гурав дахь үе шат нь нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны юм шиг харагдах болсон мөнгөө эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлдэг ажээ. Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбодог. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор хууль бус үйл ажиллагаанд зарцуулахыг зорьдог.^{1 2}

3.Хор уршиг

Мөнгө угаах нь эдийн засаг, нийгмийн ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус мөнгө гаднаас орж ирсэн бол зорилгодоо хүрээд гэнэт орж ирсэн шигээ гэнэт буцаад гарна. Их хэмжээний мөнгө гэнэтийн шилжилт нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй хямралд ч хүргэж болох юм. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг гадны орнууд авч болох юм.

¹ НҮБ-ын Палермогийн конвенц-2000 он

² НҮБ-ын Палермогийн конвенц-2000 он

Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авлигыг гааруулах, шударга өрсөлдөөнийг хавчих, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монополь байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо дутуу хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах эрсдэл өндөр юм. Манайх шиг жижиг эдийн засагтай улс оронд хөрөнгө оруулалт, мөнгөний хэрэгцээ их байгаа нь ойлгомжтой. Тэр ч хэмжээгээр банкуудад хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалтыг дэмжих сонирхол их байгаагийн зэрэгцээ банкаар дамжиж байгаа орлого, хөрөнгийн цаад эх үүсвэр, бизнесийн мөн чанарын талаар сонирхох, судлах хэрэгцээ байхгүй мэт¹ ойлгосоор удлаа. Гэтэл энэ байдал нь эргээд санхүүгийн системийн найдвартай, тогтвортой байдалд заналхийлж болзошгүй байна.^{1 2}

4.Мөнгв угаах хэлбэр

-Авлигатай холбоотой:

- Валютын арилжаа/бэлэн мөнгөний хөрвүүлэлт:
- Бэлэн мөнгө зөөвөрлөгчид/валют зөөвөрлөх:
- Мөнгө гушаах бүгцийг өөрчлөх (Structuring/smurfing):

-Зээлийн картууд, чекүүд болон энгийн вексель (promissory note) г.м:

-Шилжүүлэх боломжтой үнэт эдлэлийг худалдан авах (үнэт чулуу, үнэт металл г.м):

-Үнэтэй хөрөнгө худалдан авах (үл хөдлөх хөрөнгө, морин уралдаан, автомашин г.м

-Бараа солилцоо (бартер):

-Бэлэн бус шилжүүлгийг хэрэглэх:

-Нууц банк/албан бус гуйвуулгын үйлчилгээ (hawala, hundi г.м):

-Худалдаанд суурилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ажиллагаа:

-Тоглоомын үйл ажиллагаанууд (казино, морин уралдаан, интернетээр бооцоотой тоглох г.м):

-Ашгийн бус байгууллагыг ашиглах (ТББ):

-Санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх: Арилжих боломжтой хэрэгслүүдийг худалдан авах замаар гэмт хэргийн орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.

¹ Олон Улсын мөнгө угаах гэмт хэргийн тухай ойлголт-2015 он, УБ хот, 11-19 тал

² НУБ-ын Палермогийн конвенц-2000 он, УБ хот, 18-26 тал. орчуулга

-Холих (mingling=6Н3НесiiiiH хөрөнгө оруулалт): Мөнгө угаалтын үндсэн алхам буюу гэмт хэргийн орлогыг хууль ёсны мөнгөтэй холилдуулан эх үүсвэрийг нь нуун далдлах юм.

-Халхавч компаниуд/корпорацуудыг ашиглах: Хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс зайлсхийж, тайлагналтын харьцангуй доогуур шаардлагыг ашиглах.

ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААНТ ХОЛБОО:

Үйлдэж төгссөн гэмт хэргийн объектив тал нь нийгэмд аюултай үйлдэл эс үйлдэл, хор уршиг, шалтгаант холбоо, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн газар, арга, зэвсэг, хэрэгсэл, цаг үе, нөхцөл байдал зэрэг хэд хэдэн хэсгээс бүрдэнэ. Объектив тал нь нь аливаа гэмт хэргийн бүрэлдэхүүний гол цөм, тодорхой гэмт хэрэг, ялангуяа ойролцоо төрлийн гэмт хэргийг өөр хооронд нь зааглан ялгах шалгуур хэмээн үзэж болно. Объектив талын заавал байх шинжид нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг, шалтгаант холбоо хамаарна. Эдгээр гэмт хэрэг зөвхөн материаллаг бүрэлдэхүүнд л гарч ирнэ. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт зөвхөн нийгэмд аюултай үйлдэл л эс үйлдэхүйг шаардана. Гэмт хэрэг болгон тодорхой цаг, арга, нөхцөл байдалд үйлдэгддэг.¹

Гэмт хэргийн шалтгаант холбоо гэдэг нь: Эрүүгийн хууль зөрчсөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас буй болсон хор уршгийн хоорондын дотоод холбоо, хамаарлыг тусган илэрхийлэгч объектив орших категори бөгөөд түүний арга зүйн үндэс нь шалтгаан, үр дагаврын тухай гүн ухааны сургаал юм. Үйлдэл ба эс үйлдэл нь гэм хор бүхий хор уршигт зайлшгүй хүргэх нөхцөл болсон байдал нь шалтгаант холбоотой болохыг нотлон харуулна.

Энэ байдлаас харахад барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны санхүүжилт нь мөнгө угаах гэмт хэргийн объектив шинжийг агуулж байна.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Хууль тогтоомжийн зохицуулалт хяналт, шалгалт байхгүйгээс сүүлийн жилүүдэд энэ төрлийн бизнес идвэхжиж хулгайн эд зүйлийг хямд барьцаа нэрээр авч цаашид худалдан борлуулдаг сүлжээ үүсч хулгайн гэмт хэрэгт татагдан орох нөхцөл бүрджээ.

Ломбардууд барьцаалах зүйлээ зар нэрийн доор алт, монет, гар утас, телевизор, нөүтбүүк, мэргэжлийн камер, мөнгөн эдлэл гэх зэргээр сонгон захиалж энэ нь хулгайн гэмт хэрэг үйлдэгдэгчид санхүүжих нөхцөл боломж хангалттай бүрдэж дээрх төрлийн зүйлийг сонгон хулгайлах болов. Түүнчлэн

¹ МУ-ын Эрүүгийн эрх зүй-2017 он, УБ хот, тал-6-8

ломбардуудаас дээрх зүйлсийг чөлөөлөх нэрээр худалдан авдаг бүлэг бий болж зар сурталчилгаагаа ч явуулж байна. Бид өнөөдөр зөвхөн хулгайн гэмт хэргийг таслан зогсоохын тулд ломбардны үйл ажиллагаанд хяналт тавих мэт харагдаж байгаа ойлгож байгаа боловч нууц далд оршин байгаа мөнгө угаах, татвараас зайлс хийх гэмт үйлдлүүдийг таслан зогсооход оршиж байгаа юм. Гэтэл өнөөдөр Монгол Улсад барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль эрх зүйн орчин туйлын хангалтгүй, хяналт тавих, шалгалт хийх субъект нь тодорхойгүй байгаа зэрэг нь дээрх төрлийн гэмт үйлдлийн өгөөш болж байгааг анхаарах цаг нэгэнт болсон гэдгийг харуулж байна.

Иймд дээрх хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд уг харилцаанд тохирсон хууль эрх зүйн орчинд мэргэжлийн байгууллагыг хамруулсан улсын хэмжээний ажил арга хэмжээг зохион байгуулан явуулж ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна. 2016 онд УИХ-ын гишүүн Г.Уянга барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ явуулах харилцааг зохицуулах хуулийн төслийг санаачилж өргөн барьсан боловч ямар нэгэн дэмжлэг авалгүй буцсан байна. Хууль эрх зүйн актын гол үзэл санаа бол тухайн харилцаанд ямар нэгэн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд оршдог. Иймээс мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг арга зам нь барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх юм.

ДҮГНЭЛТ

Мөнгө угаах гэмт хэрэг нь хөгжиж байгаа оронд их үйлдэгддэг. Судалгаанаас харахад мөнгө угаах гэмт хэрэг гэсэн ойлголтыг зөвхөн өндөр албан тушаалтан \цагаан захтан\, банк санхүүгийн байгууллага, терроризм гэх мэт дэлхий нийтийг хамарсан олны анхаарлыг татсан гэмт үйлдлийн түвшинд ойлгох нь хэт өрөөсгөл юм.

Монгол улс нь хөгжиж байгаа орны тоонд ордог ба өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр 570 гаруй хууль байна. Уг хуулинд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухайн харилцааг зохицуулсан зүйл заалт, ямар нэгэн тайлбар байхгүй, эрх зүйн хийдэл ихтэй зэргээс шалтгаалан энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болсоор байна.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй барьцаалан зээлдүүлэх төвүүд 30 гаруй тэр бум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй гэсэн судалгаа байгаа нь ямар нэг хяналтгүй хууль бус мөнгө угаах, татвараас зайлс хийх гэмт үйлдлийн хэлбэрийг агуулж болзошгүй гэж дүгнэж байна.

САНАЛ

Хэн нэгэн гэмт этгээдийн хууль бусаар олсон мөнгө барьцаалан зээлдүүлэх төвүүдээр дамжин хууль ёсны мөнгө болж байгаа тохиолдол бий